

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2017 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/241/303

Улаанбаатар хот

Журам, жагсаалт батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Цагдаагийн албаны тухай хуулийн 21.1.1, 21.1.3, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Цагдаагийн байгууллага, гадаадын иргэн, харьяатын байгууллагын хамтран ажиллах журам"-ыг нэгдүгээр, "Харилцан солилцох мэдээллийн жагсаалт"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Гадаадын иргэн, харьяатын газар, Цагдаагийн ерөнхий газрын харьяа алба, нэгж, нутаг дэвсгэрийн байгууллагын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гадаадын иргэн, харьяатын газрын Дэд дарга /Д.Түвшинтөр/, Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд дарга /цагдаагийн хурандаа П.Батбаатар/-д тус тус даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын дарга, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын даргын хамтарсан 2011 оны А/250, 378 дугаар тушаал, Цагдаагийн ерөнхий газар, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар хооронд байгуулсан 2016 оны 07/008 дугаар "Мэдээлэл харилцан солилцох, хамтран ажиллах тухай гэрээ"-г тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5. Тушаалыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Ө.ЭНХТӨР

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГА



Д.МӨРӨН



**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА, ГАДААДЫН ИРГЭН,
ХАРЬЯАТЫН БАЙГУУЛЛАГЫН ХАМТРАН
АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Харьяатын тухай хууль, Цагдаагийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, мэдээ, мэдээлэл солилцох, сургалт зохион байгуулах, харилцан дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтран ажиллахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Цагдаагийн байгууллага, гадаадын иргэн, харьяатын байгууллага нь Монгол Улсын Үндсэн хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Харьяатын тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, холбогдох бусад эрх зүйн актын хүрээнд хамтран үйл ажиллагаагаа явуулна.

1.3. Хамтын ажиллагааны явцад төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээ, мэдээллийг хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд нийтэд задруулахыг хориглоно.

Хоёр. Байгууллага хоорондын хамтын ажиллагаа

2.1. Цагдаагийн байгууллага дараах асуудлаар хамтран ажиллана:

2.1.1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37.4-т заасны дагуу гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах шийдвэрийг хүлээн авсан цагдаагийн байгууллага нь дараах үүргийг гүйцэтгэнэ:

а) шаардлагатай тохиолдолд албадан гаргах гадаадын иргэнийг хилийн боомт хүртэл хуяглан хүргэх ажлыг зохион байгуулах;

б) гадаадын иргэнийг албадан гаргах ажиллагааг хэрэгжүүлэх явцад нисэх онгоцны болон галт тэрэгний буудалд олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалалт зохион байгуулах, автомашинаар хүргэх үед зам тээврийн осол гарахаас сэргийлж, шаардлагатай тохиолдолд хамгаалалт хийх;

2.1.2. Гадаадын иргэнийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27.3, Харьяатын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5, 6, 22 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу цагдаагийн байгууллага нь Гадаадын иргэн, харьяатын газрын хүсэлтийг үндэслэн санал, дүгнэлт гаргана;

2.1.3. гадаадын иргэний "гэмт хэрэг, зөрчлийн улмаас алдсан, үрэгдсэн, хаясан, гээсэн" гэж цагдаагийн байгууллагад бүртгүүлсэн паспорт, түүнийг орлох баримт бичгийн талаарх мэдээллийг тухай бүр Гадаадын иргэн, харьяатын газарт хүргүүлнэ;

2.1.4. нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага нь нутаг дэвсгэр дэх гадаадын иргэний мэдээллийг улирал тутам, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй хөдөлмөр

эрхэлсэн гадаадын иргэн илэрсэн тохиолдолд мэдээллийг тухай бүр Гадаадын иргэн, харьяатын газрын нутаг дэвсгэр дэх нэгжид тус тус хүргүүлнэ;

2.1.5.Цагдаагийн ерөнхий газар нь энэ журмын 2.2.4-т заасан мэдээллийг холбогдох алба, нэгж, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад хүргүүлж мэдээллээр хангана.

2.2.Гадаадын иргэн, харьяатын байгууллага дараах асуудлаар хамтран ажиллана:

2.2.1.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37.2 дахь хэсэгт заасны дагуу гаргасан гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах шийдвэрийг цагдаагийн байгууллагад даруй мэдэгдэж, хамтран гүйцэтгэнэ;

2.2.2.гадаадын иргэнд холбогдох асуудлыг эцэслэн шийдвэрлэх хүртэл тухайн иргэнийг Монгол Улсад зайлшгүй байх шаардлагатай гэж үзвэл цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн оршин суух зөвшөөрлийг олгох, сунгах асуудлыг Гадаадын иргэн, харьяатын газар шийдвэрлэж, хариуг мэдэгдэнэ;

2.2.3.паспорт, түүнийг орлох баримт бичиггүй гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг хэн болох нь тогтоох талаар цагдаагийн байгууллагаас ирүүлсэн хүсэлтэд хариуг даруй хүргүүлнэ;

2.2.4.гадаадын иргэдэд олгодог Монгол Улсад оршин суух үнэмлэх, визний ангилал бүрийн загвар болон тэдгээрийн нууцлалын талаарх мэдээллийг цагдаагийн байгууллагад хүргүүлнэ. Эдгээр баримт бичгийн загвар өөрчлөгдсөн даруй Цагдаагийн ерөнхий газарт мэдэгдэж, холбогдох загвар, мэдээллийг хүргүүлнэ.

Гурав. Мэдээлэл харилцан солилцох

3.1.Цагдаагийн байгууллага, гадаадын иргэн, харьяатын байгууллага нь Цагдаагийн албаны тухай хуулийн 61.4, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 22.1.1, Засгийн газрын 2013 оны 212 дугаар тогтоолоор баталсан "Төрийн байгууллагуудын цахим мэдээллийн санг ашиглах журам", энэ журмын дагуу мэдээлэл харилцан солилцоно.

3.2.Цагдаагийн байгууллага, гадаадын иргэн, харьяатын байгууллага нь "Харилцан мэдээлэл солилцох жагсаалт"-ын дагуу мэдээллийг солилцоно.

3.3.Цагдаагийн албаны тухай хууль, Гадаадын иргэний эрх зүй байдлын тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан зорилгоор мэдээллийг ашиглаж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй байна.

3.4.Цагдаагийн байгууллага, гадаадын иргэн, харьяатын байгууллага мэдээлэл хүссэн зорилго, өгсөн мэдээллийг бусдад задруулахгүй байх үүрэгтэй.

3.5.Мэдээллийн санг зөвхөн эрх олгогдсон алба хаагч ашиглана.

3.6.Мэдээллийн сан, санд хандаж байгаа програм хангамжийг хувилж тараах, бусдад шилжүүлэх, мэдээллийн сангийн сүлжээнд холбогдох эрхгүй алба хаагч, ажилтанг сүлжээнд ажиллуулах, бусдад хэрэглэгчийн нэр, нууц үгийг шилжүүлэхийг хориглоно.

3.7.Шаардлагатай тохиолдолд шууд холболт үүсгэн зөвшөөрсөн мэдээллийг харилцан солилцож болно.

3.8.Мэдээллийн сангийн үйл ажиллагаа, ашиглалтад хяналт тавьж, мэдээллийг бүх төрлийн боломжит утга, өгөгдлөөр хайлт хийх, үр дүнг жагсаалт хэлбэрээр дамжуулах боломжтой байна.

Дөрөв. Сургалт, сурталчилгааг зохион байгуулах

4.1. Гадаадын иргэний Монгол Улсад оршин суух үнэмлэх, визийн төрөл, гадаад улсын паспортын загвар, нууцлал, гадаад улсад гэмт хэрэг үйлдсэн этгээд, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, зарим тодорхой төрлийн гэмт хэрэг буюу хүн худалдаалах, терроризм болон хар тамхитай тэмцэх чиглэлээр хамтарсан сургалт зохион байгуулж, харилцан туршлага солилцоно.

4.2. Хууль тогтоомжийг сурталчлах, илрүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах талаар хамтран ажиллаж, олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилна.

Тав. Хамтран ажиллах журмын хэрэгжилтийг хангах

5.1. Энэхүү журмыг Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах алба, Гадаадын иргэн, харьяатын газрын Хяналт шалгалтын газар, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, гадаадын иргэн, харьяатын орон нутаг дахь нэгжийн дарга нар тус тус хариуцаж, зохион байгуулна.

5.2. Хамтын ажиллагааны үр дүнгийн талаарх судалгаа, мэдээллийг бүтэн жилээр гаргаж, хоёр байгууллагын удирдлагад танилцуулна.

Зургаа. Бусад зүйл

6.1. Шаардлагатай тохиолдолд ажлын хэсэг томилж, нэгдсэн удирдамж, төлөвлөгөө гаргаж ажиллана.

6.2. Цагдаа, гадаадын иргэн, харьяатын байгууллага нь хамтын ажиллагааны үр дүнг үндэслэн байгууллага, алба хаагчдыг урамшуулах асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэж болно.

6.3. Энэ журмыг зөрчсөн алба хаагчдын талаарх мэдээллийг харилцан солилцож, хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ЦЕГ ГИХГ-ын даргын 2017 оны 96 дугаар
сарын 22-ны өдрийн 1429/103 дугаар
хамтарсан тушаалын хоёрдугаар
хавсралт

ХАРИЛЦАН СОЛИЛЦОХ МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Д/д	Дамжуулах мэдээлэл	Хариуцах байгууллага
1.	Интерполоор эрэн сурвалжлагдаж байгаа сэрэмжлүүлэх мэдээлэлд дурдагдсан гадаадын иргэний мэдээлэл	ЦЕГ
2.	Интерполоор эрэн сурвалжлагдаж байгаа, алга болсон хүний мэдээлэл	ЦЕГ
3.	Олон улсад "террорист этгээд" гэж зарлагдсан этгээдийн мэдээлэл	ЦЕГ
4.	Эрэн сурвалжлалтын мэдээлэл	ЦЕГ
5.	Цагдаагийн байгууллагын нэгдсэн системд буй гадаадын иргэний зөрчлийн талаарх мэдээлэл 1.Иргэний харьяалал 2.Эцэг, эхийн нэр /латинаар/ 3.Нэр /латинаар/ 4.Төрсөн огноо 5.Хүйс 6. Паспорт, паспортыг орлох баримт бичгийн дугаар 7. Зөрчлийн төрөл, шийдвэрлэлт	ЦЕГ
6.	Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэний мэдээлэл 1.Иргэний харьяалал 2.Регистрийн дугаар /РД-тай гадаадын иргэнд хамааралтай/ 3.Эцэг /эх/-ийн нэр /латинаар/ 4.Нэр /латинаар/ 5.Төрсөн огноо 6. Хүйс 7. Паспорт, паспортыг орлох баримт бичгийн дугаар 8. Оршин суух зөвшөөрлийн хугацаа 9.Уригч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын нэр, харилцах утас 10.Оршин суугаа хаягийн бүртгэл	ГИХГ
7.	Монгол Улсын харьяат болсон, харьяатаас гарсан, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон иргэний мэдээлэл 1.Иргэний харьяалал 2.Регистрийн дугаар /РД-тай гадаадын иргэнд хамааралтай/ 3.Эцэг /эх/-ийн нэр /латинаар/ 4.Нэр /латинаар/ 5.Төрсөн огноо 6. Хүйс 7. Паспорт, паспортыг орлох баримт бичгийн дугаар 8. Зарлигийн огноо, дугаар	ГИХГ

8	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу захиргааны шийтгэл ногдуулсан болон албадан гаргаж, орохыг хориглосон гадаадын иргэний талаарх мэдээлэл 1.Иргэний харьяалал 2. Эцэг /эх/-ийн нэр /латинаар/ 3. Нэр /латинаар/ 4. Төрсөн огноо 5. Хүйс 6. Паспорт, паспортыг орлох баримт бичгийн дугаар 7. Зөрчлийн мэдээлэл 8. Зөрчлийн зүйлчлэл, шийдвэрлэлт 9.Оршин суугаа хаягийн бүртгэл	ГИХГ
9	Оршин суух үнэмлэхийн мэдээллийн сангийн талаарх мэдээлэл 1. Иргэний харьяалал 2. Эцэг /эх/-ийн, өөрийн нэр /латинаар/ 3. Паспорт, паспортыг орлох баримт бичгийн дугаар 4. Гэрэл зураг 5. Хурууны хээний мэдээлэл 6.Оршин суугаа хаягийн бүртгэл	ГИХГ